



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/116 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагууд болон нийтийн эзэмшлийн хүүхдийн тоглоомын талбайн стандарт, орчны аюулгүй байдалд хяналт шалгалт хийх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2. Захирамжийн хэрэгжилтийг ханган хяналт шалгалт зохион байгуулж, зөрчлийг илрүүлэн, арилгуулах арга хэмжээ авч, тайлан мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Болормаа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн
А.Д. дугаар захирамжийн хавсралт



БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУД БОЛОН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН
ХҮҮХДИЙН ТОГЛООМЫН ТАЛБАЙН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛД
ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Болормаа	Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч
Гишүүд:	Б.Цогжавхлан	Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга
	Ш.Баасансүрэн	Боловсролын хэлтсийн дарга
	Н.Нямзав	1 дүгээр хорооны Засаг дарга
	Б.Батзориг	2 дугаар хорооны Засаг дарга
Нарийн бичиг:	А.Анхбаяр	Багахангай дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч
	Б.Гэрэлмаа	Багахангай Тохижилт ОНӨААТҮГ-ын дарга
	Х.Дуламсүрэн	Багахангай дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч
	Г.Манлайбаатар	Хороо хариуцсан цагдаа Цагдаагийн Дэд ахлагч
	Б.Батхуяг	Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, тохижилт, орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн
	Б.Нямгарав	Засаг даргын Тамгын газрын Боловсрол, соёл, урлаг хариуцсан мэргэжилтэн